



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ СТАНДАРТ,  
ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

БАТЛАВ.

БҮТЭЭГДЭХҮҮН ТОГТОЛЦООНЫ  
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГА **В.ГАНЗОРИГ**

(тамга)

(Гарын үсэг)

2023 оны 07 сарын 05 өдөр

БАТАЛГААЖУУЛАЛТЫГ ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ ХЭРЭГЛЭХ  
ЖУРАМ

СХЗГ-07-ББ-12(03):2023

Улаанбаатар хот

Бүртгэлийн дугаар: .....

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

ХУУЛБАР ҮГЭН

Хуулбар олгосон ажлын гарын үсэг  
.....


2023 оны 07-р сарын 19 ны өдөр.



Баримт бичгийн нэр:	БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ		
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:	СХЗГ-07-ББ-12(03):2023		
Баталсан огноо:	Баримт бичгийн хувилбар:	III	

Баримт бичгийн түүх:

	Огноо	Овог нэр:	Албан тушаал:	Гарын үсэг:
Боловсруулсан:	2020.02.14	Галсандоржийн Эрдэнэбилэг	Баталгаажуулалтын газрын ахлах мэргэжилтэн	
Хянасан:	2020.02.18	Ваанчигийн Ганзориг	Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газрын дарга	
Хэлэлцүүлсэн огноо:	Хэлэлцсэн Хуралдаан: Ажлын хэсэг:		Хэлэлцүүлэгт оролцсон албан тушаалтан:	Албан тушаалтны гарын үсэг:
2020 оны 02-р сарын 18	ЧУТ-ын Ажлын хэсэг			
Хүчин төгөлдөр мөрдөж эхлэх хугацаа:	2020.03.19			





Баримт бичгийн нэр:	БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ		
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:	СХЗГ-07-ББ-12(03):2023		
Баталсан огноо:	Баримт бичгийн хувилбар:	III	

### ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БҮРТГЭЛ

№	Бүлэг №	Оруулсан өөрчлөлтийн утга	Шалтгаан	ЧМ-ийн гарын үсэг	Даргын гарын үсэг
1	Хавсралт	Халал тэмдэгийн загварыг шинээр боловсруулав	Халал баталгаажуулалт явуулах, итгэмжлэлд хамрагдах		
2	2	Халал стандартын иш таталт	Халал баталгаажуулалт явуулах, итгэмжлэлд хамрагдах		
3	5.8, 5.9	Халал тэмдэг бүтээгдэхүүнд байршуулах	Халал баталгаажуулалт явуулах, итгэмжлэлд хамрагдах		



Баримт бичгийн нэр:	БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:	СХЗГ-07-ББ-12(03).2023
Баталсан огноо:	Баримт бичгийн хувилбар: III

## 1. Зорилго

Энэхүү журмаар баталгаажуулалтын байгууллагаас баталгаажсан үйлчлүүлэгчийн аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээ "эко тэмдэг", менежментийн тогтолцоо нь тогтоосон шаардлагын дагуу нэвтрүүлж хэрэгжсэнийг гэрчилж олгосон тэмдэг хэрэглэх үйл явцыг зохицуулна.

## 2. Ашигласан баримт бичгүүд

- MNS ISO IEC 17065:2013 - Тохирлын үнэлгээ- Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээг баталгаажуулах байгууллагад тавих шаардлага

- MNS ISO/IEC 17021-1:2016 - Тохирлын үнэлгээ - Менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалт явуулдаг байгууллагад тавих шаардлага

- MNS ISO IEC 17030:2004 – Гуравдагч талын (хөндлөнгийн) тохирлын тэмдэгт тавих ерөнхий шаардлага

GSO 2055-2 Тохирлын үнэлгээ - Халал баталгаажуулалт явуулдаг байгууллагад тавих шаардлага

## 3. Тэмдэгийн загвар

3.1 Баталгаажуулалтын байгууллагаас олгож буй тэмдгийн загвар, тайлбарыг хавсралтаар тодорхойлсон. Баталгаажуулалтын статусыг гэрчлэх тэмдгийг батлагдсан загварын дагуу томруулах буюу багасган хэрэглэж болно. Тус тэмдгийн дэвсгэр цэнхэр өнгөтэй, 4.2.2-д заасан агуулгын шаардлагыг хангасан байна.

3.2 Гэрчилгээжсэн байгууллага нь гэрчлэх тэмдгийг үйлчлүүлэгч/ хэрэглэгчид болон бизнесийн түнш байгууллагууд зэрэг сонирхогч талуудад тэмдгийн талаар мэдээлэх, таниулах зорилгоор гэрчлэх тэмдгийг тохирлын гэрчилгээний хүчинтэй хугацаанд ашиглах ба өөрийн байгууллагын логоны хамт бүтээгдэхүүний хаяг шошгоны хэвлэлүүд болон дагалдах мэдээлэл хэлбэрээр байршуулан хэрэглэх боломжтой.

3.3 Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын төрөл бүр дээр гэрчлэх тэмдгийг хавсралтад заасан зааврын дагуу хэрэглэнэ.

3.4 Энэхүү гэрчлэх тэмдгийг хэрэглэснээр ямар тогтолцоо, ямар бүтээгдэхүүн, үйлчилгээг баталгаажуулсан, ямар байгууллагад хэрэглэх эрх олгосон зэрэг өгөдлүүдийг ашиглан мөшгөх боломжийг бий болгоно.

3.5 гэрчлэх тэмдэг нь хэрэглэгчийг төөрөгдөлд оруулахуйц байдлаар хоёрдмол утгыг илэрхийлж болохгүй.


## 4. Тэмдэг олгох



Баримт бичгийн нэр:	БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ		
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:	СХЗГ-07-ББ-12(03):2023		
Баталсан огноо:	Баримт бичгийн хувилбар:	III	

### АГУУЛГА

№	Гарчиг	Хуудасны дугаар
	Баримт бичгийн түүх	2
	Өөрчлөлт оруулсан бүртгэл	3
	Агуулга	4
1	Зорилго	4
2	Ашигласан баримт бичгүүд	4
3	Тэмдгийн загвар	4
4	Тэмдэг олгох	5-6
5	Тэмдэг хэрэглэх	6
6	Гэрчлэх тэмдгийн зохицуулалт	7
7	Хяналт шалгалт, үүрэг хариуцлага	8
	Хавсралт	9-12





Баримт бичгийн нэр:	БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:	СХЗГ-07-ББ-12(03)-2023
Баталсан огноо:	Баримт бичгийн хувилбар: III

4.1 Баталгаажуулалтын байгууллага нь стандарт, техникийн баримт бичгийн шаарлагад нийцсэн нээлттэй тохирлын үнэлгээний объект буюу схем (хөтөлбөр) баталгаажсаныг гэрчлэн тэмдэг олгоно.

4.2 Менежментийн тогтолцоогоор баталгаажсан үйлчлүүлэгчийн хувьд бүтээгдэхүүний сав баглаа боодол дээрх тэмдэг, дагалдах мэдээллийг дараах байдлаар зохицуулна.

4.2.1 Мэдээлэл нь:

- a) Аливаа сав, баглаа боодол, хаяг шошгон дээрх мэдээллийг тухайн бүтээгдэхүүнийг гэмтээхгүйгээр байрлуулах
- b) Дагалдах мэдээллийг хялбар ойлгомжтой байдлаар илэрхийлэх

4.2.2 Сав баглаа боодол дээрх тэмдэглэгээ нь агуулгын хувьд:

- баталгаажсан үйлчлүүлэгчийн бүтээгдэхүүний чанарыг илэрхийлэх (жишээ нь, бренд буюу нэр)
- менежментийн тогтолцооны нэр төрөл (жишээ нь, чанар, байгаль орчин ... гэх мэт) буюу холбогдох бүтээгдэхүүн буюу тогтолцооны стандартын нэрийг тусгах
- гэрчилгээ олгосон баталгаажуулалтын байгууллагын нэр .... гэх мэт

4.3 Баримт бичгийг дахин хянасан эсвэл хүчингүй болгосноос хойшх хугацаа тохирлын үнэлгээний объект буюу схемийн үйлчлэх хугацаатай нийцнэ.

## 5. Тэмдэг хэрэглэх

5.1 Гэрчлэх тэмдгийг менежментийн тогтолцоог олон улсын болон үндэсний стандарт, техникийн баримт бичгийн шаардлагын дагуу нэвтрүүлж хэрэгжүүлснээ эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаар баталгаажуулж гэрчилгээжсэн байгууллага хэрэглэнэ.

5.2 Баталгаажуулалтын байгууллагаас олгосон тэмдгийг бүтээгдэхүүн эсвэл бүтээгдэхүүний сав баглаа боодол дээр байрлуулж болно.


5.3 Мэдэгдэхүйц оюу ихтэй биет бүтээгдэхүүн дээр гэрчлэх тэмдгийг шууд байршуулна. Харин овор хэмжээ болон хэлбэрт зохицоогүй бүтээгдэхүүний хувьд тэмдгийг сав баглаа боодол буюу бусад дагалдах байдлаар хэрэглэнэ.

5.4 Гэрчлэх тэмдгийг ишлэл татах буюу сурталчилгааны баримт бичгүүдэд гэрээний дагуу дараах байдлаар хэрэглэнэ. Үүнд:

- хэвлэл, сурталчилгааны материал
- танилцуулга, байгууллагын танилцуулга хэвлэл
- эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл
- ажлын тайлан ... гэх мэт

5.5 Баталгаажсан үйлчлүүлэгч тэмдэгээ лабораторийн туршилт, шалгалт тохируулга буюу бүтээгдэхүүний тайлан байдлаар хяналтын тайланд хэрэглэж болохгүй.

5.6 Баталгаажсаныг гэрчлэх тэмдэг, тохирлын гэрчилгээ түүний хавсралтыг Монгол хэл дээр хэвлэх ба шаардлагатай тохиолдолд Англи хэлээр хэвлэж болно.





Баримт бичгийн нэр:	БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:	СХЗГ-07-ББ-12/03/2023
Баталсан огноо:	Баримт бичгийн хувилбар: ■

5.7 Баталгаажуулалтын байгууллагын нэр, хаяг эсвэл бусад өөрчлөлтүүд орсон тохиолдолд дахин хянаж батлагдсаны дараа үргэлжлүүлэн хэрэглэх боломжтой.

5.8 Халал баталгаажуулалтын тэмдэгийг бүтээгдэхүүн тус бүрийн шошгонд байршуулсан байна.

5.9 Хэрвээ тухайн бүтээгдэхүүнийг багцлан хайрцаг(шуудай)-нд савлах бол хайрцагны гадна талд халал тэмдэг/логог байршуулсан байна.

## 6. Гэрчлэх тэмдгийн зохицуулалт

6.1 Баталгаажуулалтын байгууллага болон баталгаажсан үйлчлүүлэгч хооронд гэрээ байгуулж гэрчлэх тэмдгийг эзэмших ба гэрээнд дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:

- интернет, тохимол буюу сурталчилгаа бусад баримт, бичиг зэрэг мэдээллийн хэрэгслээр баталгаажуулалтын эрх зүйн байдлыг иш татахдаа баталгаажуулалтын байгууллагаас зөвшөөрөл авсан байх

- баталгаажуулалтад хамааралтай аливаа төөрөгдөлд оруулах мэдэгдэл хийх буюу олон нийтийн итгэл найдварыг алдахад хүргэх байдлаар баталгаажуулалтын статусыг ашиглахгүй байх

- баталгаажуулалтын баримт бичиг ба түүний аливаа хэсгийг төөрөгдүүлэх байдлаар ашиглахгүй байх

- баталгаажуулалтыг хүчингүй болгох үед баталгаажуулалтын ишлэл татсан бүх зар сурталчилгааг үргэлжлүүлэн хэрэглэхгүй байх

- хамрах хүрээг багасгасан тохиолдолд бүх сурталчилгаанд өөрчлөлт оруулах

- менежментийн тогтолцооны баталгаажуулалтыг ишлэл татаж хэрэглэхгүй байх

- баталгаажуулалтын байгууллагын олгосон хамрах хүрээнээс гаднах үйл явцад ашиглахгүй байх ... гэх мэт

6.2 Итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн хүрээг өргөтгөсөн буюу багасгасан эсвэл аливаа өөрчлөлт орсон тохиолдолд сүүлчийн хувилбарыг ашиглана.

6.3 Шаардлагатай тохиолдолд тэмдэг эзэмшигч буюу олгогч хуулийн этгээд нь нууцын зэрэглэлээс бусад мэдээллийг дээд байгууллага буюу олон нийтэд цаг тухайд нь гаргаж өгнө.

6.4 Тэмдэг эзэмшигч буюу олгогч нь тэмдэг бүхий бүтээгдэхүүн, тогтолцооны байгууллагын жагсаалтын бүртгэлийг хөтөлж хадгалах ба байнга шинэчилж байвал зохино.

## 7. Хяналт шалгалт, үүрэг хариуцлага

7.1 Баталгаажуулалтын байгууллага нь санал гомдлын мөрөөр баталгаажсан үйлчлүүлэгчийн схемийн дагуу тохирлын гэрчилгээ, тэмдэг эзэмших болон хэрэглэх, хадгалах явцад хяналт шалгалт явуулна.



Баримт бичгийн нэр:	БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ	
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:	СХЗГ-07-ББ-12(03):2023	
Баталсан огноо:	Баримт бичгийн хувилбар:	III

Хавсралт

## БАТАЛГААЖУУЛАЛТЫГ ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭ



Энэхүү тэмдгийг тогтолцооны баталгаажуулалтын тухайн төрөлд Стандарт, хэмжил зүйн газраас олгосон гэрчилгээн дээр хэрэглэх ба энэ тэмдгээр дамжуулан баталгаажуулагдсан тогтолцооны төрөл, баталгаажуулалтын байгууллагыг эргээд мөшгөх боломжийг бий болгохын зэрэгцээ тухайн баталгаажуулалтын байгууллагын явуулж буй ISO 9001 гэх зэрэг тогтолцооны төрөл тус бүрийн баталгаажуулалтын хөтөлбөрийг тодорхойлно.



Энэхүү гэрчлэх тэмдэг нь чанарын удирдлагын тогтолцоо нь тогтоосон шаардлагад тохирч байгааг тэмдэглэх ба уг тэмдгийг гэрчилгээжсэн байгууллага нь үйлчлүүлэгчид, хэрэглэгчид болон бизнесийн түнш байгууллагууд зэрэг сонирхогч талууддаа энэ тухайгаа мэдээлэх, таниулах зорилгоор баталгаажуулалтын байгууллагаас олгосон гэрчилгээний хүчинтэй хугацаанд ашиглан өөрийн байгууллагын логоны хамтаар бүтээгдэхүүний хаяг шошгын хэвлэлүүд болон бусад дагалдах мэдээлэлд байршуулан хэрэглэх боломжтой. Тэмдгийг ашиглах шаардлагыг “Тохирлын үнэлгээ-Гуравдагч талын (хөндлөнгийн) тохирлын тэмдэгт тавих ерөнхий шаардлага” ISO IEC 17030:2004 стандартыг удирдамж болгог гэрчилгээ эзэмшүүлэгч болон эзэмшигчийн хооронд гэрээгээр зохицуулна.



Баримт бичгийн нэр:	БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ		
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:	СХЗГ-07-ББ-12(03):2023		
Баталсан огноо:	Баримт бичгийн хувилбар:	III	


7.2 Баталгаажуулалтын схемийг буруу иш татсан эсвэл тохирлын гэрчилгээ, баримт бичиг буюу бусад зар сурталчилгаанд хэрэглэгчийг төөрөгдөлд оруулах буюу хуурамчаар ашигласан тохиолдолд дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Залруулах
- Тохирлын гэрчилгээ, тэмдгийг хүчингүй болгох
- Алдааг залруулан хэвлэх
- Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн дагуу холбогдох мэргэжлийн байгууллагад мэдэгдэнэ.

7.3 Баталгаажуулалтын байгууллагатай байгуулсан гэрээний дагуу үйлчлүүлэгч тэмдгийг ашиглалт хариуцаж буй чанарын менежер эзгүй байх тохиолдолд орлох хүнийг томилно.



7.4 Баталгаажуулалтын тэмдгийг түдгэлзүүлэх буюу цуцлах тухай шийдвэр гарснаас хойш тэмдэг эзэмшигч нь ажлын 3 хоногт багтаан хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.


**Төгсөв.**







Баримт бичгийн нэр:	БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ		
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:	СХЗГ-07-ББ-12(03):2023		
Баталсан огноо:	Баримт бичгийн хувилбар:	III	

№	Стандарт, хэмжил зүйн газраас олгодог баталгаажуулалтын тэмдгийн төрөл	Баталгаажуулалтын тэмдгийн тайлбар
1		ISO 9001 – Чанарын удирдлагын тогтолцооны олон улсын стандартын шаардлага хангасан.
2		ISO 22000 – Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны олон улсын стандартын шаардлага хангасан.







Баримт бичгийн нэр:	БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ		
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:	СХЗГ-07-ББ-12(03):2023		
Баталсан огноо:	Баримт бичгийн хувилбар:	III	

№	Стандарт, хэмжил зүйн газраас олгодог баталгаажуулалтын тэмдгийн төрөл	Баталгаажуулалтын тэмдгийн тайлбар
3		<p>HACCP—Hazard Analysis and critical control point's буюу эгзэгтэй цэгийн аюултай байдлын шинжлэн хяналт-олон улсын стандартын шаардлага хангасан.</p>
4		<p>ISO 14000 – Байгаль орчны удирдлагын тогтолцооны олон улсын стандартын шаардлага хангасан.</p>



Баримт бичгийн нэр:	БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧЛЭХ ТЭМДЭГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ		
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:	СХЗГ-07-ББ-12(03):2023		
Баталсан огноо:	Баримт бичгийн хувилбар:	III	

№	Стандарт, хэмжил зүйн газраас олгодог баталгаажуулалтын тэмдгийн төрөл	Баталгаажуулалтын тэмдгийн тайлбар
5		<p>БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ нь Монгол Улсын үндэсний стандартын шаардлага хангасан.</p>
6		<p>HALAL-OIS/SMICC 1, GSO 2055-1, GSO 993-стандартын шаардлага хангасан.</p>

Бүртгэлийн дугаар: .....  
**БАЯН-ӨЛГИЙ АРГААНИ**  
**СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН**  
 2023 оны 07-р сарын 19-ны өдөр